



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Вэбсайт: www.bayankhongor.gov.mn

Утас/Факс: (976) 7044 2273

2022.01.06 № 2/49

танай _____-ны № _____-т

Г ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ 7
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Иргэдээс төрийн захиргааны байгууллага,
албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл,
гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны жилийн эцсийн
тайлан мэдээг хүргүүллээ.

Хавсралт 6 хуудастай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

616220081

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

Иргэдээс Баянхонгор аймгийн төрийн байгууллага,
албан тушаалтанд гаргасан өргөдөл,
гомдлын 2021 оны шийдвэрлэлт

2022 оны 01 дүгээр сарын 05

Номгон

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны байгууллагууд нь иргэдээс санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2014 оны 202 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний санал, хүсэлтийг бодлого шийдвэртээ тусгаж ажиллах зарчмыг баримтлан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн нийт 14245 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авснаас аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 290 санал, хүсэлт, өргөдөл, гомдол, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагт 6082, сумдын Засаг даргын Тамгын газарт 7561, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 312 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт бичгээр 290 өргөдөл ирснээс 215 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж 62 өргөдөл гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлсэн. Нийт ирсэн өргөдлийг агуулгаар нь ангилж үзвэл ажил хүссэн 38 , гэр хүссэн 31, газрын асуудлаар 52, мөнгөн тусламж хүссэн 25, бусад асуудлаар 144 өргөдөл, хүсэлт ирсэн байна.

Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой болон эмчилгээний зардал, мөнгөн тусламж хүссэн 10 иргэнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.600.000 төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

Аймгийн Засаг даргын 2014 оны 202 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/259 дүгээр захирамжаар “Аймгийн нутгийн захиргааны байгууллага,

албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ыг шинэчлэн батлууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 17-ны А/65 дугаар тушаалаар "Иргэдээ сонсьё" аяныг эхлүүлж, "Иргэдээ сонсьё-Баянхонгор" фэйж хуудсаар төрийн нэр бүхий 8 байгууллагын үйл ажиллагаа, цахим хуудасны ил тод байдал, үйлчилгээний чанар хүртээмж иргэдийн сэтгэл ханамж ямар байгааг тандах зорилгоор судалгаа хийх ТББ-ыг сонгон шалгаруулсан. Тус шалгаруулалтад "Хөгжилд залуучуудын оролцоо түншлэл" төрийн бус байгууллага шалгарч 10 хоногийн хугацаанд судалгааг хийж дүнг нэгтгэсэн.

Мөн "Зөөлөн чих" фэйж хуудсыг ажиллуулан иргэдээс санал сэтгэгдлийг нь хүлээн авсан. Судалгааны үр дүнгийн мэдээллийг аймгийн удирдлагууд болон тухайн судалгаанд хамрагдсан 8 байгууллагуудын удирдлагуудад танилцуулж гарц, шийдлийн талаар мэдээлэл солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт удирдлагууд болон холбогдох хэлтсийн мэргэжилтэн, ТББ, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдээс бүрдсэн нийт 36 хүн оролцож санал бодлоо хуваалцаж, хэлэлцүүлгээс гарсан санал, хүсэлт, шийдвэрлэх асуудлуудын талаар зөвлөмжийг тухайн байгууллагуудад нь хүргүүлсэн. Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмж, цахим хуудасны ил тод байдал сайжирсан үзүүлэлттэй байна.

"Төрийн байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг иргэн та хэрхэн үнэлэх вэ?" 34 асуулт бүхий санал асуулгыг боловсруулж, цахимаар 20 сумын 157 иргэнийг хамруулан сэтгэл ханамжийн судалгаа авсан. Төрийн байгууллагуудын үйлчилгээний талаар иргэдийн дийлэнх нь хангалтгүй үнэлгээ өгсөн. Үнэлгээний дагуу холбогдох хэлтсүүдэд чиглэл хүргүүлэхээр ажиллаж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн нээлттэй утас 70440001 дугаараар 312 дуудлага хүлээн авснаас аймгийн Онцгой комисстой холбоотой 265, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 35 санал хүсэлт ирүүлсэн хүсэлтийг тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд шилжүүлэн ажилласан.

Засгийн газрын 1111 төвд 23 санал, гомдол ирүүлснийг холбогдох албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлж иргэнд хариуг утсаар мэдэгдэж ажилласан байна.

Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Пүрэв гарагт иргэдийг хүлээн авч иргэдийн санал хүсэлтийг сонсож байна. Тус онд аймгийн Засаг даргын иргэдтэй уулзах уулзалтыг өргөтгөсөн байдлаар тусгайлан 10 удаа зохион байгууллаа. Энэ

хүрээнд 316 иргэн өөрсдийн санал, хүсэлт, тулгамдаж байгаа асуудлаа харилцан ярилцсан. Уулзалтад ирсэн иргэдийн асуудлыг агуулгаар нь ангилан авч үзвэл: 18 хувь нь ажлын байр, 32 хувь нь тусламж дэмжлэг хүсэж байгаа бол 16 хувь нь орон гэр, 34 хувь нь газрын асуудлаар ханджээ. Ковид 19 цар тахлын нөхцөл байдлын улмаас халдварын тархалтаас сэргийлж "Аймгийн Засаг даргын иргэд хүлээн авах өдөр"-ийн зохион байгуулалтад өөрчлөлт орж, цөөн тооны иргэдийг биечлэн хүлээн авах уулзалтын цагийг өгч бүртгэлжүүлэв. Түүнчлэн тухайн уулзалтын үеэр Аймгийн Засаг даргаас иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг цаг алдалгүй шийдвэрлэж ажилласан.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь бүтэн жилийн байдлаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай, нээлттэй үзүүлсэн Үүнд: E-hutuch.mn цахим хуудасны талаар брошур бэлтгэн үйлчлүүлсэн иргэдэд тарааж мэдээлэл өгч, E-Mongolia цахим хуудаснаас 400, Хур системээс 3682 иргэнд лавлагаа гаргаж үйлчилсэн байна. Мөн 5 төрийн байгууллагын 180 гаруй төрлийн үйлчилгээг 25835 иргэнд үйлчилсэн байна.

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМБЫН ГАЗРЫН
ДАРГА

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ҮДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Д.ЭНХЖАРГАЛ

С.ЛХАМХОРОЛ

**ИРГЭДЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

2022 оны 01 дүгээр сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувиар
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шилжүүлсэн	Хугацаа болоогүй	
1	Засаг даргын Тамгын газар	290	215	62		13	95.5%
2	Хэлтэс агентлаг	6082	5883	77	9	113	98.1%
3	Сумын ЗДТГ	7561	7396	47	10	108	98.5%
4	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв 70440001	312	213				
Дүн		14245	13707	186	19	234	97.6%

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

С.ЛХАМХОРОЛ

ИРГЭДЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ХЭЛБЭРЭЭР

2022 оны 01 дүгээр сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Үүнээс						
			Бичгээр	11-11 төв болон 7044001 дугаараар	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн үүлсэн	Бусад	
1	Засаг даргын Тамгын газар	290	290						
2	Хэлтэс агентлаг	6082	5326			268	241	247	
3	Сумын ЗДТГ	7561	7515			4	8	32	2
4	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв 70440001	312			23		289		
Дүн		14245	13131	23	272	538	279	2	

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

С.ЛХАМХОРОЛ

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН
АГУУЛГА, ХУВЬ

2022 оны 01 дүгээр сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал Тоо нийт өргөдөл, гомдлын эзлэх хувь
1	Баянхонгор	<p>Нийт 14245 өргөдлөөс</p> <p>1.Хүсэлт- 13863 (97.3%)</p> <p>2.Санал- 71 (0.4%)</p> <p>3.Гомдол- 311 (2.1%)</p> <p>Ажил хүссэн- 724 (5%)</p> <p>Тусламж дэмжлэг хүссэн- 1797 (12.6%)</p> <p>Газрын асуудлаар- 1594 (11.1%)</p> <p>Гэр хүссэн- 37 (0.2%)</p> <p>Нийгмийн даатгалын асуудлаар- 1501 (10.5%)</p> <p>Нийгмийн халамжийн асуудлаар- 2518 (17.6%)</p> <p>Иргэний бүртгэлтэй холбоотой асуудлаар- 1875 (13.1%)</p> <p>Худалдаа үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл хүссэн- 305 (2.1%)</p> <p>Байгууллагын дотоод асуудалтай холбоотой (Чөлөө хүссэн.... гэх мэт)- 485 (3.4%)</p> <p>Бусад асуудлаар- 3409 (23.9%)</p>

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

С.ЛХАМХОРОЛ